

**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ
ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ,
ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН
ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.



МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ, ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА (2022 ОНЫ ЭХНИЙ 4 САРЫН ГҮЙЦЭТГЭЛ)



Нэг. Гадаад худалдааны үзүүлэлт

Гадаад худалдааны нийт бараа эргэлт: 2022 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт **5,148.7** сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 15.5

хувь буюу 690.8 сая ам.доллараар өсөж, гадаад худалдааны тэнцэл **450.0** сая ам.долларын ашигтай гарсан байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	4 дүгээр сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт (өмнөх оны мөн үеэс)	
	2019	2020	2021	2022	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	4,278.2	2,959.9	4,457.9	5,148.7	690.8	15.5
-Экспорт	2,512.0	1,373.6	2,496.7	2,799.3	302.7	12.1
-Импорт	1,766.2	1,586.3	1,961.2	2,349.3	388.1	19.8
Тэнцэл	745.8	-212.7	535.4	450.0	-85.4	-16.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: 2022 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл **450.0** сая ам.долларын ашигтай гарсан байна. Гадаад худалдааны тэнцэл өмнөх оны мөн үеэс 85.4 сая ам.доллар буюу 16.0 хувиар буурсан байна.

Экспорт: Экспортын худалдаа 2022 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр **2,799.3** сая ам.долларт хүрч, эдийн засаг хэвийн байсан 2019 оны мөн үетэй харьцуулахад 287.3 сая ам.доллар буюу 11.4 хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад

302.7 сая ам.доллар буюу 12.1 хувиар өссөн байна.

Импорт: 2022 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр импорт **2,349.3** сая ам.долларт хүрч, 2019 оны мөн үетэй харьцуулахад 583.1 сая ам.доллар буюу 22.0 хувиар, 2021 оны мөн үеэс 388.1 сая ам.доллар буюу 19.8 хувиар тус тус өссөн байна.

Хоёр. Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн

Нийт экспортын **83.4** хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, **16.6** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна. Эрдсийн бүтээгдэхүүний экспорт **2,334.6** сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс

150.7 сая ам.доллар буюу 6.9 хувиар өссөн бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт **464.8** сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 152.0 сая ам.доллар буюу 48.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 2. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	4 дүгээр сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2019	2020	2021	2022	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	2,119.7	1,206.5	2,183.9	2,334.6	150.7	6.9	83.4
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	392.3	167.1	312.8	464.8	152.0	48.6	16.6
Нийт экспорт	2,512.0	1,373.6	2,496.7	2,799.3	302.7	12.1	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЭКСПОРТЫН ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ БОЛОН ҮНИЙН ДҮН

Нийт экспортын 38.0 хувийг нүүрс, 36.1 хувийг зэсийн баяжмал, 11.7 хувийг боловсруулаагүй алт, 3.6 хувийг төмрийн

хүдэр, 2.9 хувийг цайрын баяжмал тус тус эзэлсэн байна.

Хүснэгт 3. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	4 дүгээр сар (өссөн дүнгээр)				Өмнөх оны мөн үеэс	
		2019	2020	2021	2022	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	489.1	429.4	390.8	469.3	78.5	20.1
Нүүрс	сая.тн	11.4	4.1	7.3	3.8	-3.5	-48.2
Төмрийн хүдэр, баяжмал	сая.тн	2.8	2.7	2.6	1.0	-1.6	-61.1
Цайрын хүдэр, баяжмал	мян.тн	54.1	50.2	43.0	40.7	-2.3	-5.4
Алт	тн	4.7	1.6	0.9	5.4	4.6	518.3
Боловсруулаагүй нефть	сая.баррель	2.1	0.5	1.9	0.0	-1.9	-100.0
Катодын зэс	тн	3.0	3.8	4.2	2.1	-2.1	-50.0
Жоншны баяжмал	мян.тн	110.6	197.4	256.9	77.4	-179.4	-69.9
Адууны мах	мян.тн	7.7	2.7	4.4	0.2	-4.2	-95.5
Өлөн гэдэс	тн	140.9	205.8	250.3	229.0	-21.3	-8.5

Үхэр, адууны боловсруулсан шир	сая.дм2	28.2	20.7	2.6	0.2	-2.4	-91.9
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	0.0	62.0	527.5	0.7	-526.8	-99.9
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая.дм2	13.9	26.8	17.6	0.0	-17.6	-100.0
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая.дм2	86.9	62.5	36.7	36.5	-0.2	-0.6
Самнасан ноолуур	тн	43.7	50.2	79.8	139.6	80.7	137.1
Бохир ноолуур	тн	1,300.0	38.6	862.1	1,115.0	252.9	29.3
Хонины самнаагүй ноос	мян.тн	4.0	2.2	3.9	0.1	-3.8	-97.9

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 4. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/

Барааны төрөл	4 дүгээр сар (өссөн дүнгээр)				Өмнөх оны мөн үеэс	
	2019	2020	2021	2022	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	701.4	486.3	774.0	1,010.2	236.2	30.5
Нүүрс	961.0	334.0	758.6	1,064.4	305.8	40.3
Төмрийн хүдэр	159.0	188.7	336.3	102.1	-234.2	-69.6
Цайрын баяжмал	78.7	62.6	65.2	80.0	14.8	22.8
Алт	195.9	80.4	50.1	326.9	276.8	552.3
Боловсруулаагүй нефть	118.5	20.7	105.8	0.0	-105.8	-100.0
Катодын зэс	18.4	20.8	36.4	20.9	-15.5	-42.6
Жоншны баяжмал	40.6	50.3	54.7	18.8	-35.9	-65.6
Адууны мах	14.3	5.5	9.1	0.5	-8.6	-94.6
Өлөн гэдэс	3.0	3.5	5.5	5.3	-0.1	-2.3
Үхэр, адууны боловсруулсан шир	2.9	2.0	0.6	0.12	-0.4	0.0
Үхэр, адууны боловсруулаагүй шир	0.0	0.1	0.7	0.02	-0.7	-97.6
Хонь, хурганы боловсруулсан арьс	0.3	0.7	0.3	0.0	-0.3	-0.1
Ямаа, ишигний боловсруулсан арьс	2.9	2.3	1.1	0.7	-0.4	-37.5
Самнасан ноолуур	3.4	4.4	4.9	16.5	11.6	239.1
Бохир ноолуур	69.6	1.6	33.9	52.5	18.6	54.9
Хонины самнаагүй ноос	6.5	2.2	3.8	0.2	-3.6	-95.5
Нийт экспортод эзлэх хувь	94.6%	92.2%	89.8%	96.4%		

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оны мөн үеэс **150.7** сая ам.доллар буюу **6.9** хувиар өсөхөд голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

1.Нүүрс: 2022 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр **3.8** сая тонн нүүрс экспортолж, **1,064.4** сая ам.долларын экспортын орлого олжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспортын биет хэмжээ 3.5 сая тонноор буурсан бол экспортын орлого 305.8 сая ам.доллараар буюу 40.3 хувиар өссөн байна. Нэг тонн нүүрсний экспортын дундаж үнэ өмнөх оны мөн үеэс 176.2 ам.доллар буюу 1.7 дахин нэмэгдсэн нь нүүрсний экспортын орлогыг өсөхөд голлон нөлөөлжээ.

2.Зэсийн баяжмал: 2022 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр зэсийн баяжмалын экспортын биет тоо хэмжээ 469.3 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 20.1 хувь буюу 78.5 мянган тонноор өссөн. Зэсийн баяжмалын экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 30.5 хувь буюу 236.2 сая ам.доллараар өсөж, 1,010.2 сая ам.долларт хүрсэн байна. Энэ нь экспортын дундаж үнэ 8.7 хувиар өссөнөөс шалтгаалжээ.

3.Цайрын баяжмал: 2022 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр цайрын баяжмалын экспортын тоо хэмжээ **40.7** мянган тонн болж, **80.0** сая ам.долларын экспортын орлого олсон байна. Цайрын баяжмалын экспортын орлого өмнөх оны мөн үеэс 22.8 хувь буюу 14.8 сая ам.доллараар өссөн байна. Цайрын баяжмалын биет хэмжээ 5.4 хувь буюу 2.3 мянган тонноор буурсан боловч нэг тонн цайрын баяжмалын экспортын дундаж үнэ 29.6 хувиар өссөн байна.

4.Алт: 2022 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр алтны экспортын тоо хэмжээ 5.4 тоннд хүрч, 326.9 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Алтны экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 5.2 дахин өссөн ба эдийн засаг хэвийн байсан 2019 оны мөн үеэс 777.9 кг буюу 16.7 хувиар өссөн байна. Алтны экспортын орлого өмнөх оны мөн үеэс 5.5 дахин буюу 276.8 сая ам.доллараар өсчээ. Мөн нэг тонн алтны экспортын дундаж үнэ 8.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Гурав. Гол нэр төрлийн импортын бүтээгдэхүүн

Нийт импортын **21.5** хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, **78.5** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт **505.3** сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс **141.1**

сая ам.доллараар буюу 38.7 хувиар өссөн байна.

Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт **1,844.0** сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 247.0 сая ам.доллар буюу 15.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 5. Эрдсийн болон эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	4 дүгээр сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2019	2020	2021	2022	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	409.6	344.7	364.3	505.3	141.1	38.7	21.5
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	1,356.7	1,241.6	1,597.0	1,844.0	247.0	15.5	78.5
Нийт импорт	1,766.2	1,586.3	1,961.2	2,349.3	388.1	19.8	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын барааны бүтцийн хувьд эрдэс бүтээгдэхүүн **21.5** хувь, машин механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг **16.4** хувь, мал амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний зүйл **14.9** хувь, авто болон агаарын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги **13.4** хувь, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн **10.4** хувь, химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн **7.1** хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 6. Импортын гүйцэтгэл, барааны бүлгээр

/сая ам.доллар/

№	Барааны нэр	Импорт		Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
		2021.04	2022.04	Дүн	Хувь	
1	Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	33.6	51.8	18.2	54.1	2.2
2	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	95.8	50.6	-45.2	-47.2	2.2
3	Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	17.8	16.8	-1.0	-5.5	0.7
4	Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	168.8	230.9	62.1	36.8	9.8
5	Эрдэс бүтээгдэхүүн	364.3	505.3	141.1	38.7	21.5
6	Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	153.0	167.9	14.8	9.7	7.1
7	Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс, хаймар болон түүгээр хийсэн зүйлс	73.0	99.7	26.6	36.5	4.2
8	Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	1.7	2.4	0.7	37.9	0.1
9	Мод, модон эдлэл	11.5	31.0	19.5	169.7	1.3
10	Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	18.0	32.0	14.0	77.5	1.4
11	Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	27.8	45.1	17.2	62.0	1.9
12	Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	6.1	9.3	3.2	52.7	0.4
13	Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	42.5	63.6	21.1	49.6	2.7
14	Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	2.1	3.2	1.1	52.9	0.1
15	Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	130.2	244.0	113.9	87.5	10.4
16	Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	340.6	386.0	45.3	13.3	16.4
17	Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги	414.0	314.6	-99.4	-24.0	13.4
18	Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг, тэдгээрийн эд анги	34.7	48.6	14.0	0.0	0.0
19	Зэвсэг, галт хэрэгсэл, тэдгээрийн эд анги болон тоног хэрэгсэл	1.6	0.5	-1.0	0.0	0.0
20	Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	23.9	46.0	22.1	0.1	0.0
21	Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	0.1	0.0	-0.1	-0.1	0.0
	ДҮН	1,961.2	2,349.3	388.1	19.8	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Дөрөв. Улсын төсвийн гаалийн орлого бүрдэлт

Гаалийн байгууллага Сангийн сайдын 2022.03.01-ний өдрийн “Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” 51 дүгээр тушаалаар батлагдсан төлөвлөгөөгөөр 2022 оны 4 дүгээр сард улсын төсөвт 1,269.4

тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 1,264.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 99.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 7. Татварын орлогын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2021.04		2022.04		Өмнөх оны мөн үетэй харьцуулахад		Төлөвлөгөөтэй харьцуулахад	
	Гүйц.	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь	Зөрүү	Хувь	
Нийт орлого	1,007.9	1,269.4	1,264.0	256.1	125.4	-5.4	99.6	
Гаалийн албан татвар	262.1	325.6	341.2	79.1	130.2	15.6	104.8	
Нэмэгдсэн өртгийн албан татвар	531.4	670.2	698.6	167.2	131.5	28.4	104.2	
Архи, дарсны онцгой албан татвар	4.7	6.8	7.4	2.7	157.4	0.6	108.8	
Тамхины онцгой албан татвар	40.7	38.8	46.4	5.7	114.0	7.6	119.6	
Шар айрагны онцгой албан татвар	1.3	0.8	1.4	0.1	107.7	0.6	175.0	
Суудлын автомашины онцгой албан татвар	59.2	82.5	82.3	23.1	139.0	-0.2	99.8	
Автобензин, дизель түлшний онцгой албан татвар	85.7	117.5	67.8	-17.9	79.1	-49.7	57.7	
Автобензин, дизель түлшний албан татвар	4.1	4.1	5.9	1.8	143.9	1.8	143.9	
Экспортын татвар	0.024	0.0033	0.0052	0.0	0.0	0.0	0.0	
Татварын дүн	989.2	1,246.3	1,251.0	261.8	126.5	4.7	100.4	
Өөрийн орлого	1.7	6.0	2.7	1.0	158.8	-3.3	45.0	
Хураамж	17.0	17.1	10.3	-6.7	60.6	-6.8	60.2	

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого **256.1** тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд:

- Гаалийн албан татвар **79.1** тэрбум төгрөг;
- Нэмэгдсэн өртөгийн албан татвар **167.2** тэрбум төгрөг;
- Архи, дарсны онцгой албан татвар **2.7** тэрбум төгрөг;
- Тамхины онцгой албан татвар **5.7** тэрбум төгрөг;
- Шар айрагны онцгой албан татвар **0.1** тэрбум төгрөг;
- Суудлын автомашины онцгой албан татвар **23.1** тэрбум төгрөг;
- Автобензин, дизель түлшний албан татвар **1.8** тэрбум төгрөгөөр тус тус өссөн.

Харин автобензин, дизель түлшний онцгой албан татвар **17.9** тэрбум төгрөг, хураамжийн орлого **6.7** тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Зарим төрлийн импортын бараанд ногдуулсан онцгой албан татварын орлого бүрдэлт, импортын тоо хэмжээний талаар:

Онцгой албан татвартай суудлын автомашин: Тус барааны онцгой албан татвараар 2022 оны эхний 4 сард 82.5 тэрбум төгрөг төсөвт төвлөрүүлэхээс 82.3 тэрбум төгрөг төвлөрүүлж 99.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Өнгөрсөн оны мөн үетэй орлогыг харьцуулахад 23.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Тайлант хугацаанд онцгой албан татвартай суудлын автомашин 19,736 ширхгийг импортлосон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2,177 ширхэг буюу 12.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс, хос тэжээлт болон шингэрүүлсэн хийгээр ажилладаг суудлын автомашин 758 ширхгээр, бусад суудлын автомашин 1,419 ширхгээр тус

тус өсчээ. Ногдуулсан татварын хэмжээг авч үзвэл:

- Автобензин, дизелийн хөдөлгүүрээр ажилладаг автомашин /цаашид "бусад" гэх/ онцгой албан татвартай автомашин – 28.1 тэрбум төгрөг;
- Хос тэжээлт болон, шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашин – 50.8 тэрбум төгрөг тус тус ногдуулжээ.

Хүснэгт 8. Онцгой албан татвартай суудлын автомашины импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар

Төрөл	Импортын тоо хэмжээ /ширхэг/				Ногдуулсан татвар /тэрбум төгрөг/			
	2021.04	2022.04	Зөрүү	Хувь	2021.04	2022.04	Зөрүү	Хувь
Хос тэжээлт	13,850	14,608	758	105.5	40.6	50.8	10.2	125.1
Бусад	3,709	5,128	1,419	138.3	18.7	28.1	9.4	150.3
Нийт	17,559	19,736	2,177	112.4	59.3	78.9	19.6	133.1

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Автобензин, дизелийн түлш: Монгол Улс шатахууны хэрэгцээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд өмнөх оны мөн үед 482.1 мянган тонн, 2022 оны эхний 4 сарын сард **469.0** мянган тонн автобензин, дизелийн түлшний бүтээгдэхүүн импортолсон байна.

Хүснэгт 9. Автобензин, дизелийн түлшний импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар

Төрөл		Импортын тоо хэмжээ /мян.тонн/				Ногдуулсан татвар /тэрбум төгрөг/			
		2021.04	2022.04	Зөрүү	Хувь	2021.04	2022.04	Зөрүү	Хувь
Нийт		482.1	469.0	-13.1	97.3	84.0	60.6	-23.4	72.1
Автобензин	A-80	16.5	12.2	-4.3	73.9	0.0	0.0	0.0	0.0
	A-92	112.3	182.2	69.9	162.2	0.0	0.0	0.0	0.0
	A-95 болон түүнээс дээш	5.7	9.9	4.2	173.7	1.2	2.0	0.8	166.7
Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин		0.0	5.8	5.8	100.0	0.0	1.6	1.6	100.0
Дизель түлш		347.6	258.9	-88.7	74.5	82.8	57.0	-25.8	68.8

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хураамжийн орлого: Гаалийн байгууллага улсын төсөвт хураамжийн орлогоор **17.1** тэрбум төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс **10.3** тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний гүйцэтгэл 60.5 хувьтай байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хураамжийн орлого 6.7 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Экспортод гаргасан эрдэс бүтээгдэхүүний гаалийн бүрдүүлэлтийн хураамж нь нийт хураамжийн орлогын 92.0 хувийг эзэлж байна.

Хүснэгт 10. Гол нэрийн эрдэс бүтээгдэхүүний экспортын хураамжийн орлого

/мянган тонн, сая төгрөг/

Экспортын эрдэс бүтээгдэхүүний гол нэрийн бараа	2021.04		2022.04		Өөрчлөлт 2022/2021	
	Тоо хэмжээ	Хураамж	Тоо хэмжээ	Хураамж	Тоо хэмжээ	Хураамж
Жонш	256.9	385.3	77.4	116.2	-179.5	-269.2
Төмрийн хүдрийн баяжмал	2,615.1	3,922.7	1,017.5	1,526.2	-1,597.7	-2,396.5
Зэсийн баяжмал	390.8	586.2	469.3	703.9	78.5	117.7
Цайрын баяжмал	43.0	64.5	40.7	61.0	-2.3	-3.5
Чулуун нүүрс	7,312.9	10,969.4	3,791.4	5,687.1	-3,521.5	-5,282.2
Хүрэн нүүрс	171.5	257.2	-	-	-171.5	-257.2
Түүхий нефть/мянган баррель/	1,890.2	2.8	-	-	-1,890.2	-2.8
Бусад		51.7		2.5	0.0	-49.2
Нийт		16,239.8		8,096.9		-8,143.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Тав. Татварын чөлөөлөлт

2022 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр нийт татвараас чөлөөлөгдсөн импорт үнийн дүнгээр **246.4** тэрбум төгрөг буюу нийт импортын 3.7 хувийг эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татвартай импорт **1,571.0** тэрбум төгрөг буюу 132.2 хувиар өссөн бол, татвараас чөлөөлөгдсөн

импорт 411.3 тэрбум төгрөг буюу 37.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Татвараас чөлөөлөгдсөн импортын нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **8.2** нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 11. Импортын бүтэц

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2021.04	2022.04	Өөрчлөлт (+,-)	Хувиар
Татвартай импорт	4,874.2	6,445.2	1,571.0	132.2%
<i>Эзлэх хувь</i>	<i>88.1%</i>	<i>96.3%</i>	<i>8.2%</i>	
Татвараас чөлөөлөгдсөн импорт	658.1	246.4	-411.3	37.5%
<i>Эзлэх хувь</i>	<i>11.9%</i>	<i>3.7%</i>	<i>-8.2%</i>	
Нийт импорт	5,532.3	6,692.0	1,159.7	121.0%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2022 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр 246.4 тэрбум төгрөгийн импортын бараанд ногдох 41.9 тэрбум төгрөгийн татвар хуулийн дагуу чөлөөлөгдсөн байна. Чөлөөлөгдсөн татварын дүнг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 67.4 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн БНМАУ-ЗСБНХУ-ын хооронд байгуулсан 1949 оны хэлэлцээр, мөн УИХ-ын 2016.09.07-ны өдрийн “Онцгой албан татвараас чөлөөлөгдөх тухай хууль”-ийн хүрээнд 68.3 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **17.0** тэрбум төгрөгийн татвар;
2. Засгийн газрын болон Олон улсын байгууллагын тусламжийн хүрээнд 35.8 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **4.9** тэрбум төгрөгийн татвар;
3. Засгийн газрын болон Олон улсын байгууллагатай байгуулсан зээлийн хүрээнд 54.4 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **8.1** тэрбум төгрөгийн татвар;
4. Хийн түлш, тэдгээрийн тоног төхөөрөмж 28.6 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **4.4** тэрбум төгрөгийн татвар;
5. Бусад төрлийн барааны хувьд татварын холбогдох хуулийн зүйл, заалтуудаар 30.0 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **4.2** тэрбум төгрөгийн татварыг тус тус чөлөөлсөн байна.

Д/д	Үзүүлэлт	2021.04		2022.04		Өөрчлөлт 2022/2021	
		үнийн дүн	чөлөөлсөн татвар	үнийн дүн	чөлөөлсөн татвар	үнийн дүн	чөлөөлсөн татвар
1	Улаанбуудайн үр, хүнсний улаанбуудай, бүх төрлийн хүнсний будаа, элсэн чихэр, ургамлын тос	254.5	39.0	0.0	0.0	-254.5	-39.0
2	Гадаадын хөрөнгө оруулалт: УБТЗ	175.9	26.7	68.3	17.0	-107.6	-9.7
3	Засгийн газрын болон Олон улсын байгууллагын тусламж	52.7	8.1	35.8	4.9	-16.8	-3.2
4	Иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоц, түүний сэлбэг	41.9	6.5	0.5	0.1	-41.5	-6.4
5	Засгийн газрын болон Олон улсын байгууллагын зээл	28.8	4.2	54.4	8.1	25.6	3.9
6	Хийн түлш, тэдгээрийн тоног төхөөрөмж	17.1	2.7	28.6	4.4	11.5	1.8
7	Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг	3.1	0.5	2.6	0.4	-0.4	-0.1
8	ХАА-н зориулалттай тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис	0.0	0.0	26.2	2.7	26.2	2.7
9	Бусад	84.1	21.7	30.0	4.2	-54.1	-17.5
	Дүн	658.1	109.3	246.4	41.9	-411.6	-67.4

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Зургаа. Улсын төсвийн гаалийн орлого бүрдэлтэд нөлөөлсөн хүчин зүйлс

Импорт: Эдийн засгийн нөхцөл байдал эргэн сэргэж гадаад худалдааны бараа эргэлт өмнөх оны мөн үеэс 15.5 хувиар илүү байна.

Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 338 дугаар тогтоолын дагуу үүрэг болгосноор гаалийн байгууллага нь гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг хийж эхлүүлээд байна.

Тухайлбал, Замын-Үүд дэх гаалийн газар нь чингэлэг терминалын үйл ажиллагааг эхлүүлсэнтэй холбогдуулан уртасгасан цагаар ажиллаж, ААН, иргэдийн ачааг олгож эхэлсэн. Коронавируст цар тахлын улмаас БНХАУ-ын Эрээн хотын боомтын бараа эргэлтийн хязгаарлалтаас хамаарч агаарын тээвэрлэлт 4-5 дахин өссөн үзүүлэлтэй холбоотойгоор Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар уртасгасан цагаар ажиллаж байгааг гаалийн байгууллага мэдэгдсэн байна.

Татварын чөлөөлөлт: Татвараас чөлөөлөгдсөн импортын нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8.2 нэгж хувиар буурсан нь 2022 оны эхний 4 сарын байдлаар татвараас чөлөөлөгдсөн импортын барааны хэмжээ багассантай холбоотой байна. 2021 онд хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан (хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүн, малын тэжээлийг Гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх, Коронавируст халдварын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортоор оруулж ирсэн оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис амны хаалтыг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх тухай) хуулиудын дагуу нийт 63.0 тэрбум төгрөгийг татвараас чөлөөлж байжээ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС